



УЛААНБААТАР
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 5/432

Улаанбаатар хот

Б.Тайширыг ажлаас чөлөөлж,
тэтгэмж олгох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8, 38 дугаар зүйлийн 38.1.1, 40.1.3, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, Компанийн Хөдөлмөрийн дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.23, Компанийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2019-2020 онд мөрдөх Хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан Трансформаторын албаны гагнуурчин Баастын Тайшир /121396/-ыг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлж, хөдөлмөрийн гэрээг цуцалсугай.

2. Б.Тайширт эрчим хүчний салбарт 30 жил ажилласны тэтгэмжийг эрчим хүчний салбарт ажилласан жил тутамд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /672000 төгрөг/-г 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцож 40 320 000 /дөчин сая гурван зуун хорин мянга/ төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг олгосугай.

3. Б.Тайширт нэг удаагийн тэтгэмжийн 40 320 000 /дөчин сая гурван зуун хорин мянга/ төгрөг олгохыг Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /О.Ариунболд/-д зөвшөөрсүгэй.

4. Б.Тайширын ажлыг хүлээлцүүлж, ээлжийн амралтын олговрыг 10.32 хоногоор олгох, холбогдох тооцоог хийж дуусгахыг Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /О.Ариунболд/, Трансформаторын албаны дарга /Б.Батцэнд/ нарт үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга /Б.Баттүшиг/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.ДАГДАН